



**ХЭНТИЙ АЙМГИЙН  
МӨРӨН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН  
ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ**

2025 оны 06 сарын 27 өдөр

Дугаар A/35

Мөрөн сум

**“Орон нутаг судлах танхим”-ын ажлын  
явцад хяналт тавих, хүлээн авах  
комисс байгуулах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Сумын Засаг даргын 2025 оны 03 сарын 27-ний өдрийн А/58 тоот захирамжаар байгуулагдсан Сумын үнэлгээний хорооны 2025 оны 05 сарын 02-ний өдрийн 11 тоот зөвлөмжийг тус тус үндэслэн ТУШААХ нь.

1. “ГЭРЭГЭ ДИЖИТАЛ МЕХНОЛОГИ”- ХХК нь сумын ОНХ сангийн хөрөнгө оруулалтаар “ОРОН НУТАГ СУДЛАХ ТАНХИМ”-ын ажлын тендэрт ялж 2025 оны 05 сарын 18 аас 2025 оны 07 сарын 03 -ний дотор хийж гүйцэтгэх гэрээ байгуулсан тул уг ажлын явцад хяналт тавих, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах, хүлээн авах эрх бүхий сумын комиссыг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай

Комиссын дарга: Цэндбаяр

Соёлын төвийн эрхлэгч

Гишүүдэд: А.Алимаа

Нийгмийн бодлогын мэргэжилтэн

Г.Дашмаа

Төрийн сангийн мэргэжилтэн

Г.Хишигбаатар

Хууль эрх зүйн мэргэжилтэн

Б.Лхагвасүрэн

Өвийн ажилтан

2. “ГЭРЭГЭ ДИЖИТАЛ МЕХНОЛОГИ” ХХК -аас хүлээн авах “ОРОН НУТАГ СУДЛАХ ТАНХИМ”-ын ажлыг гэрээний хавсралт болох техникийн тодорхойлолтыг үндэслэн тоо ширхэг, өнгө үзэмж, чанар байдлыг нэг бүрчлэн шалгаж, фото зургаар баримтжуулан акт үйлдэж хүлээн авахыг комиссын дарга (Ц.Цэндбаяр)-т үүрэг болгосугай.

3. “ОРОН НУТАГ СУДЛАХ ТАНХИМ” байгуулах үйл ажиллагаанд захиалагчийн зүгээс хөндлөнгийн хяналт хийхдээ холбогдох мэргэжлийн байгууллагуудтай хамтран ажиллаж тэднээс заавар зөвлөмж авч захиалагчийн чиг үүргийг хэрэгжүүлж ажиллахыг комиссын нийт гишүүдэд даалгасугай.

ДАРГА

Н.НАМЖИЛНОРОВ